



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/263

Номгон

“Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар
зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах,
2022 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.3 дахь заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх хэсэг, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны “Салбар зөвлөл байгуулах тухай” 03 дугаар тогтоолоор баталсан “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.3, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Баянхонгор аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөтэй уялдуулан сумын салбар зөвлөлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнахыг сумын салбар зөвлөлийн дарга сумдын Засаг, аймгийн салбар зөвлөлийн гишүүдэд тус тус даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Наранбаярт үүрэг болгосугай

4.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөл байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/263 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220207

Аймгийн Засаг дарга 2022 оны 02 дугаар сарын
14-ний өдрийн А/83 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт



ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМГИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын дэргэдэх Насан туршийн боловсролын төвийн захирал

Аймгийн Нийтийн номын сангийн захирал

Үндэсний лаборатори "Номундалай" цогцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

Баянхонгор сумын ерөнхий боловсролын "Эрдэнэмандал" ахлах сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

Хэл соёлоо эрхэмлэгч иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Боловсрол, шинжлэх ухааны газрын Монгол хэл, уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн

_____ оОо _____

Аймгийн Засаг даргын 2022 он 03 дугаар сарын
14-ний өдрийн А/БЗ дугаар захирамжийн
хоёрдугаар табиарт



**ХЭЛНИЙ БОДЛОГЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Монгол хэлний тухай хуулийн заалт, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ын зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулах төсөв, эх үүсвэр /сая төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5	6	7	8
1 дүгээр зорилт: Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх							
1.1	"Монгол хэлний тухай хууль" -ийн 17.1.1 харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах	Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах		Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Баянхонгор аймгийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.	I сард	Хэлний бодлогын аймгийн зөвлөлийн гишүүд	Хэлний бодлогын сумдын зөвлөл
1.2		Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөлийн 2021 оны ажлын тайланг дүгнэх, 2022 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах	0.5	Хэлний бодлогын аймаг, сумын зөвлөлийн 2021 оны үйл ажилагаанд үнэлгээ хийж, тус оны "Тэргүүний зөвлөл"-ийг шагнаж урамшуулах, сурталчлан таниулах ажлыг гүйцэтгэнэ.	I сард	Хэлний бодлогын аймгийн зөвлөлийн гишүүд	Хэлний бодлогын сумдын зөвлөл, Насан туршийн боловсролын нэгж
1.3		"Эх хэлний өдөр", "Үндэсний бичиг, үсгийн өдөр"-ийг аймаг, сум орон нутагт тэмдэглэн өнгөрүүлэх	Орон нутгийн төсвөөс	"Эх хэлний өдөр", "Үндэсний бичиг, үсгийн өдөр"-ийг тэмдэглэсэн байна.	IX, V сард	ЕБС-ууд	Сумдын ЗДТГ
1.4		Хэлний бодлогын сумын салбар зөвлөл хууль, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жил тутам аймгийн		Хэлний бодлогын сумын салбар зөвлөл тайлангаа хагас жил тутам аймгийн зөвлөлд хүргүүлсэн байна.	VI, XII сард	Хэлний бодлогын сумын салбар зөвлөл	ЗДТГ, НТБТ

1	2	3	4	5	6	7	8
		Хэлний бодлогын зөвлөлд ирүүлэх					
1.5		Аймгийн "Оны тэргүүний салбар зөвлөл"-ийг шалгаруулж, урамшуулах	0.5	Хэлний бодлогын сумын салбар зөвлөлийн тайлан, үр дүнгийн үзүүлэлтийг үндэслэн "Оны тэргүүний салбар зөвлөл"-өөр 5 сумыг шалгаруулна.	XII сард	Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл	Хэлний бодлогын сумын салбар зөвлөл
1.6		Аймаг, сумын төрийн байгууллагын албан хаагчдын судалгааг авч, нэгтгэх		Аймаг сумын төрийн байгууллагын албан хаагчдын судалгааг авч, нэгтгэсэн байна.	II сард	Аймаг, сумын хэлний бодлогын салбар зөвлөл	НТБТ
1.7	МХТХ-19.1.1, 19.1.3 27.1.9, МБҮХ-III.1.11. Монгол бичгээр хэвлэгддэг сонин, сэтгүүлийн давтамжийг нэмэгдүүлэхэд санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх	Төрийн байгууллага, албан хаагчид 7 хоног тутам хэвлэгддэг "Хүмүүн бичиг" сонинг захиалж, монгол бичгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	Байгууллага, иргэдийн хөрөнгө	"Хүмүүн бичиг" сонин захиалсан байгууллага, албан хаагчийн тоо, хэрэглэж хэвшсэн байдал, уншигчийн тоо өссөн байна.	Улирал тутам	Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, албан хаагч, ажилчид	"Хүмүүн бичиг" сонины газар, "Монгол шуудан" ХХК
1.8	МХТХ-21.7.6, 17.1.2 21.7.12, МБҮХ-III 1.13. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, нэрийн хуудас, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн гадаад болон албан өрөөний хаяг, гудамж талбайн хаягжилтийг хос бичгээр бичих ажлыг үргэлжлүүлэх	Тухайн байгууллага, аж ахуй нэгжийн төсвөөс	Төрийн болон төрийн бус байгууллагын хаягийг хос бичгээр бичсэн тоогоор дүгнэнэ.	Жилийн турш	Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал	Хэлний бодлогын аймаг, сумын салбар зөвлөл
1.9		Аж ахуй нэгж байгууллагын бараа бүтээгдэхүүний шошго, танилцуулгыг монгол бичгээр бичих уриалга гарган ажиллах	Тухайн аж ахуй нэгжийн төсвөөс	Аймгийн аж ахуй нэгж, байгууллагын бараа бүтээгдэхүүний нэрийг монгол бичгээр бичиж хэвшсэн тоон үзүүлэлтээр дүгнэнэ.	Жилийн турш	Аж ахуй нэгж, байгууллага	Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл

1	2	3	4	5	6	7	8
2 дугаар зорилт: Монгол бичигт сургах ажлыг эрчимжүүлж, шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх							
2.1	МХТХ-13.1.1, БТХ-45.1.8 МБҮХ-III 2.7 Монгол улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн сургуульд монгол хэл, бичгийн хичээлийг заавал судлах эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангах, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын цагийн хэрэгжилтэд хяналт тавих	ЕБС-ийн монгол хэл, бичгийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих		Ерөнхий боловсролын сургуулийн 30-аас доошгүй хувийг хамруулсан байна.	Жилийн турш	БШУГ	Аймгийн төвийн болон сумын ЕБС
2.2	МХТХ-13.1.1, БТХ-45.1.8 МБҮХ-III 2.7 Монгол улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн сургуульд монгол хэл, бичгийн хичээлийг заавал судлах эрх зүйн зохицуулалтыг бүрэн хангах, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын цагийн хэрэгжилтэд хяналт тавих	ЕБС-ийн XII анги төгсөгчдийн эх хэл бичгийн болон ЭЕШ /мхб/-д бэлтгэх ажлыг зохион байгуулах		Эх хэл бичгийн болон монгол хэлний ЭЕШ-ыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна. Шалгалтын оноогоор улсын дунджаас дээгүүр амжилт үзүүлсэн байна	II-V сард	БШУГ	Аймгийн төвийн болон сумын ЕБС
2.3	МХТХ-13.1.1, 21.7.2 МБҮХ-III 2.13. Монгол бичгийн улсын олимпиад, уралдааныг зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх	Төрийн албан хаагчдын дунд “Үндэсний бичгийн массын олимпиад” зохион байгуулах	1.0	Тусгай удирдамжийн дагуу 2 үе шаттай олимпиадыг зохион байгуулсан байна.	X-XI сард	Нийгмийн бодлогын хэлтэс, БШУГ, НТБТ	Баянхонгор сумын ЗДТГ
2.4		Засаг даргын нэрэмжит “Үндэсний бичгийн чадварын шалгалт”-ыг авах	0.5	БШУГ-аас мониторинг хийх үедээ сумдын төрийн албан хаагчдаас түүврийн аргаар шалгалт авч, анализ хийнэ.	III, IV сард	Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл	Хэлний бодлогын сумдын салбар зөвлөл, НТБТ
2.5		ЕБС-ийн VIII ангийн сурагчдын дунд “Хос бичигтэн хамт олон” удирдамжит ажлыг зохион байгуулах	0.6	Сурагчдын кирил ба үндэсний бичгээр бичих болон уран яруу унших чадварт ахиц гарсан байна. Уралдаант ажилд оролцсон сурагчийн тоогоор дүгнэнэ.	X-XI сард	БШУГ	ЕБС-ийн удирдлага, монгол хэл бичгийн багш нар
2.6		XI ангийн сурагчдын дунд “Уран бичлэг”, “Хичээнгүй бичлэг”-ийн төрлөөр уралдаан зохион байгуулах	0.4	Сурагчдын бичгийн хэв соёл дээшилж, уран бичлэгийн чадварт ахиц гарсан байна.	III-IV сард	БШУГ, АННС	ЕБС

1	2	3	4	5	6	7	8
2.7		Төрийн албан хаагчдын дунд үндэсний бичгийн олимпиадыг үе шаттай зохион байгуулах	0.5	Монгол бичгийн ур чадвар, мэдлэгийн түвшин ахисан байна.	IV сард	Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл	ЕБС-иудын МХБ-ийн багш нар, ард иргэд
2.8		Мэргэжлийн багш нарын дунд монгол бичгийн олимпиадыг зохион байгуулах	0.5	Монгол хэл, бичгийн багш нарын мэдлэг чадвар ахисан байна.	V сард	Хэлний бодлогын салбар зөвлөл	ЕБС-ийн багш нар
2.9	МХТХ-9.1.4 17.1.3 МБҮХ-III 2.14. Монгол бичгийн албан бус сургалт явуулах эрх олгох, сургалт явуулж буй хувь хүн, хуулийн этгээдийг хөхиүлэн дэмжих	Үндэсний бичгийн сургалт эрхлэх хувь хүн, сургалтын төвүүдэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	Орон нутгийн төсвөөс	Сургалт эрхлэх шаардлага хангасан сургалтын байгууллага, иргэний тоо	I-XII сард	Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл, НТБТ	Аймаг, сумдын Засаг дарга, иргэд
2.10		Насан боловсролын туршийн төвийг түшиглэн, монгол бичгийн сургалтын төв байгуулах	20.0	Сургалтын стандарт хангахуйц сургалтын төвийг байгуулсан байна.	Жилдээ	Нийгмийн бодлогын хэлтэс, НТБТ	Хэлний бодлогын аймгийн салбар зөвлөл
2.11		Бүсийн хэмжээнд "Үндэсний бичигтэн- Жишиг сум"-ыг шалгаруулж, сурталчлан таниулах	Орон нутгийн төсвөөс	Тусгай удирдамжийн дагуу шалгуур үзүүлэлт, болзлуудыг хангасан байх	XI сард	Аймаг, сумдын Засаг дарга, удирдлагууд	ХБСЗ, ЕБС-иуд
2.12	МХТХ-9.1.4, 17.1.3 МБҮХ-III- 2.15. Байгууллага, хамт олноороо монгол бичигтэн болох аян өрнүүлэх	Төрийн албан хаагчдын монгол хэл бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг түвшний ялгаатай зохион байгуулсан байдал, ахиц амжилтын үзүүлэлтийг хянах, дүгнэх	Албан байгууллага аж ахуй нэгжийн төсвөөс	Зохион байгуулсан сургалтын тоо, сургалтад оролцсон хүний тоогоор	II- XI сард	Аймаг, сумдын Хэлний бодлогын салбар зөвлөл	НТБТ Төрийн байгууллагууд
2.13		ЕБС-ийн монгол хэл бичгийн багш, сурагчдын "Бийрийн бичлэг"-ийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	ЕБС болон багш, сурагчдын хөрөнгөөс	Монгол хэл бичгийн 60 -аас доошгүй багшийг сургалтад оролцуулах Сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулах	Жилдээ	БШУГ	Хэлний бодлогын аймаг, сумдын салбар зөвлөл, НТБТ

1	2	3	4	5	6	7	8
		“Хос бичигтэн-Баянхонгор” тайлант арга хэмжээ, үзэсгэлэнг зохион байгуулах	Албан байгууллага, аж ахуй нэгжийн төсвөөс	Сумдын хэлний бодлогын салбар зөвлөл үйл ажиллагаа явуулсан арга хэмжээг сурталчлан таниулсан байна.	XI- XII сард	Аймаг, сумдын Хэлний бодлогын салбар зөвлөл	ЕБС-иуд, НТБТ, АННС
3 дугаар зорилт: Албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах							
3.1	МХТХ-9.1.5 МБҮХ-III-3.5. Албан бичиг хэргээ кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн хөтөлж хэвшсэн төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагыг 2023 оноос эхлэн урамшуулах	“Зөв бичгийн журамласан толь”-ийг ашиглан төрийн албан бичгийн хэрэг хөтлөлт, хичээл сургалтад хэрэглээ болгох		Зөв бичгийн журамласан толь”-ийг төрийн албан бичиг хэрэг хөтлөлт, хичээл сургалтад хэрэглээ болгох ба файл, апп суулгасан иргэдийн тоо	Жилдээ	Аймаг, сумдын Хэлний бодлогын салбар зөвлөл	ЕБС-иуд, НТБТ
3.2		Төрийн байгууллагын бичиг хэргийн ажилтнуудад үндэсний бичгийн сургалт зохион байгуулж, цахим бичвэрт сургах	Байгууллагын төсвөөс	Монгол бичгийн цахим бичвэрийн сургалтад хамрагдсан бичиг хэргийн ажилтны тоогоор	V сард	Аймаг, сумдын Хэлний бодлогын салбар зөвлөл	Төрийн байгууллага, НТБТ
4 дүгээр зорилт: Монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох							
4.1	МХТХ-19,20 МБҮХ-III 4.4. Монгол бичгийн контентыг дэмжиж, нэр төрлийг олшруулах	Монгол бичгийг богино хугацаанд шинэлэг хэлбэр, хялбар аргаар сургах цахим контент, цахим хичээл, теле хичээлийн сан үүсгэж баяжуулах		Цахим контент, хичээлийн тоогоор	V-XI сард	Аймаг, сумдын Хэлний бодлогын салбар зөвлөл	ЕБС-иуд
		Төрийн албан хаагчдад зориулсан монгол бичгийн “Дасгал ажлын дэвтэр”-ийг бэлтгэн боловсруулах, хэвлэлтэд өгөх арга хэмжээг зохион байгуулах	10.0	Монгол бичгийн дадлага ажлын дэвтэрийг эмхэтгэн боловсруулж, хэвлэлтэд өгсөн байна.	Жилдээ	ЕБС-ийн багш нарын баг	НБХ, Хэлний бодлогын салбар зөвлөл

1	2	3	4	5	6	7	8
4.2	МХТХ- 11.1.3 МБҮХ-III 4.5. Насан туршийн боловсролын төвүүдэд албан бус сургалтаар иргэдэд монгол бичиг сургах сургалтын эрх зүйн орчин бүрдүүлэх	Насан туршийн боловсролын төвүүдэд байгууллага, хамт олон, иргэдэд зориулсан монгол бичгийн хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах		Сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулсан байна.	V-XI сард	НТБТ	ЕБС-иуд
Нийт төсөв : 14.500.000 /Арван дөрвөн сая таван зуун мянга/							

-----oOo-----